



**ОРХОН АЙМГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР**

Улаан-Үүдийн гудамж, Хүрэнбулаг баг,
Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61027
Утас: (976) 7577 6699

Цахим шуудан: Orhon@ndaatgal.mn
Цахим хуудас: ndaatgal.or.gov.mn

2025.07.03 № 378
танай 2025.06.27 -ны № 02/1585 -т

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗАРТ**

Тус газрын Шилэн дансны тухай хуулийн
хэрэгжилтэд хяналт шалгалт хийсэн ажлын тайланг
хүргүүлж байна.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРМАНДАХ



612716384



ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025 ОНЫ 02-Р УЛИРЛЫН ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛЬ, ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2025 оны 07-р сарын 03-ны өдөр

Орхон аймаг

Нэг. Хяналтын үндэслэл

Нийгмийн даатгалын ерөнхий газрын Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 11-ны өдрийн 02/529 тоот албан даалгаврын дагуу Шилэн дансны тухай хууль тогтоомж, Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам” үндэслэнэ.

Хоёр. Хяналтын зорилго

Шилэн дансны цахим хуудасны Нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын үйл 2025 оны 02-р улирлын хөтлөлт, мэдээлэл байршуулсан байдал, холбогдох шийдвэрийн хуулбар, баримт бичгийг бүрэн оруулсан эсэхэд хяналт хийж, зөрчлийг арилгуулахад зорилго оршино.

Гурав. Хяналтын хамрах хүрээ

Шалгалтыг 2025 оны 02-р улирлын Шилэн дансны цахим хуудсанд Нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын үйл ажиллагааны мэдээлэл байршуулсан байдал, холбогдох шийдвэрийн хуулбар, баримт бичгийг бүрэн оруулсан эсэхэд 2025 оны 07 дүгээр сарын 01-ны өдрөөс 2025 оны 07 дүгээр сарын 03-ны өдрийн хооронд хугацаанд Нийгмийн даатгалын газрын Захиргаа, хяналтын хэлтсийн дарга Г.Галбадрах шалгалтыг хийж гүйцэтгэн ажилласан.

Дөрөв. Шилэн дансны хөтлөлт, мэдээлэл байршуулсан байдал

- Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын үйл ажиллагааны шилэн дансны нийт 171 мэдээлэл оруулахаас хагас жилийн байдлаар хугацаандаа оруулсан мэдээлэл 78, хугацаа хоцорсон мэдээлэл 12, мэдээлэл оруулаагүй 5, мэдээлээгүй 89 байна
- Орхон аймгийн Нийгмийн даатгалын сангийн шилэн дансны нийт 159 мэдээлэл оруулахаас хагас жилийн байдлаар хугацаандаа оруулсан мэдээлэл 79, хугацаа хоцорсон мэдээлэл 6, мэдээлэл оруулаагүй 3, мэдээлээгүй 83 байна.

Тав. Хяналтын үр дүн

Үйл ажиллагааны мэдээлэл оруулахдаа:

- Сар бүр, жил бүр, Тухай бүр оруулах мэдээний хавсралт цэсэд мэдээлэл байршуулаагүй, хавсралтад оруулах мэдээллээ дутуу, буруу оруулж тайлагнасан боловч тухай бүр оруулах мэдээллээ сүүлийн саруудад хоцролгүй оруулж байгаа сайн талтай байна.
- Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө



зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр гэсэн цэсэд мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаалуудыг бүрэн байршуулсан нь өмнөх улиралд гаргасан алдаагаа залруулсан үр дүнтэй байна.

Сангийн мэдээллийн оруулахдаа:

- Сар бүр, жил бүр, Тухай бүр оруулах мэдээний хавсралт цэсэд мэдээлэл байршуулаагүй тайлангаа оруулсан.
- Тухай бүр оруулах мэдээллийг хугацаа хоцорч оруулах, оруулах мэдээллийн дүнг андуурч шивэх зэрэг алдаанууд байна.

Зургаа. Шилэн дансны мэдээлэл байршуулалттай холбоотой илэрсэн зөрчил

Үйл ажиллагааны шилэн дансны дансны мэдээлэлд:

- 1.Сар бүр, жил бүр, Тухай бүр оруулах мэдээний хавсралт цэсэд мэдээлэл байршуулаагүй тайланг оруулсан.
- 2.Төсвийн хэтрэлт хэмнэлтийн тайлбарыг оруулаагүй тайлагнасан.
3. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр гэсэн цэсэд мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаалуудыг бүрэн байршуулсан боловч хугацаа хоцроож байршуулсан.

Сангийн шилэн дансны дансны мэдээлэлд:

1. Сар бүр, жил бүр, Тухай бүр оруулах мэдээний хавсралт цэсэд мэдээлэл байршуулаагүй тайланг оруулсан.
2. Тухай бүр оруулах мэдээллийн байршуулалт хангалтгүй байна.

Долоо. Зөвлөмж

Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулгыг харгалзах оруулах мэдээлэл байхгүй үед шалтгааныг нь тайлбарлан бичиж, дарааллын дагуу бүх цэсийг бүрэн дарж баталгаажуулах, мэдээ оруулах хуулийн хугацааг өдөр бүр орж шалгаж хэвших, хэмнэлт хэтрэлтийн тайлбарыг бүрэн гүйцэт бичиж оруулах, тухай бүр оруулах мэдээллийг шийдвэр гарсны дараа 7 хоногийн дотор байршуулах, хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоотой тушаал шийдвэрийг нягтлан бодогчид 5 хоногийн дотор өгч хэвшиж, хавсралт цэстэй байгаа мэдээлэлд хавсралтыг бүрэн оруулж цаашид алдаа дутагдлаа давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах

Найм. Дүгнэлт

Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын дагуу төсвийн байгууллага үйл ажиллагааны болон нийгмийн даатгалын сангийн нийт 330 мэдээллээс нэгдүгээр улиралд сар, улирал бүр, эхний хагас, бүтэн жилээр оруулах мэдээллээс хуулийн хугацаанд 157 мэдээллийг байршуулан, 1 мэдээллийг хоцроож тайлагнасан ба тухай бүр оруулж байршуулах мэдээллийг шийдвэр, орлого зарлагын гүйлгээ хийсний дараа 7 хоногийн дотор байршуулаагүй хугацаандаа хоцорсон мэдээлэл 18, мэдээлэл оруулаагүй 8 байсан



зэрэг алдаа дутагдлаа дээд газрын болон дотоодын шалгалтын явцад арилгах арга хэмжээ авч ажиллаж байна.

Ес. Цаашид авах арга хэмжээний санал

- 1.Цаашид алдаа дутагдлаа давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах
- 2.Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл оруулах сургалтыг мэргэжлийн болон дээд шатны байгууллагаас өгсөн зөвлөмжийг заалт бүрээр мөрдөж ажиллах
- 3.Цаашид мэдээлэл хоцроохгүй байхад чиглэсэн ажлын хуваарилалтаа сайжруулах арга хэмжээ, зохион байгуулалт хийж ажиллах

ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН:

ЗАХИРГАА, ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Г.ГАЛБАДРАХ